



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2020 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 689

Улаанбаатар хот

“Сүү” ХК-ийн нэмж гаргаж буй
энгийн хувьцааг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай 9 дүгээр зүйлийн 9.1, 63 дугаар зүйлийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 42 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 5.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сүү” ХК-ийн нийтэд санал болгон нэмж гаргах нэг бүр нь 10 мөнгөний нэрлэсэн үнэтэй 85,589,000 /наян таван сая таван зуун наян есөн мянга/ ширхэг энгийн хувьцааг бүртгэн тус компанийн нийт гаргасан хувьцааг 429,589,000 /дөрвөн зуун хорин есөн сая таван зуун наян есөн мянга/ ширхэг байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газар /С.Цэрэндаш/-т үүрэг болгож, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ж.Байгалмаа/-д зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолын 1-д заасан хувьцаанаас 77,030,100 /далан долоон сая гучин мянга нэг зуу/ ширхэг хувьцааг тогтоосон үнийн аргаар тус бүрийн үнийг 218 /хоёр зуун арван найм/ төгрөгөөр “Сүү” ХК-ийн тодорхойлсон стратегийн хөрөнгө оруулагчид худалдахыг “Сүү” ХК /М.Мандхай/-д зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоолын 1-д заасан хувьцаанаас 8,558,900 /найман сая таван зуун тавин найман мянга есөн зуу/ ширхэг хувьцааг олон нийтэд тогтоосон үнийн аргаар 218 /хоёр зуун арван найм/ төгрөгөөр худалдахыг “Сүү” ХК /М.Мандхай/-д зөвшөөрсүгэй.

4. Энэ тогтоолын 2, 3-д заасан нийтэд санал болгон нэмж гаргаж буй хувьцааг 100 /нэг зуу/ хувь зах зээлд арилжаалсан тохиолдолд үнэт цаасыг анхдагч зах зээлд нээлттэй худалдах ажиллагааг амжилттай болсонд тооцохыг “Сүү” ХК /М.Мандхай/-д мэдэгдсүгэй.

5. Энэ тогтоолын 2-д заасан хувьцааг стратегийн хөрөнгө оруулагчид бүхэлд нь худалдан авахаар мөнгөн хөрөнгийг холбогдох дансанд байршуулсан талаарх тодорхойлолтыг андеррайтерийн компани болон “ҮЦТХТ” ХХК-аас Хороонд ирүүлсэн нөхцөлд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12.2-д заасан анхдагч зах зээлд үнэт цаасыг арилжих зөвшөөрөл олгохыг “Сүү” ХК /М.Мандхай/, “Нэйшил сэкоритис ҮЦК” ХХК /Ц.Наран-Учрал/-д тус тус мэдэгдсүгэй.

6. Хорооноос анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцсон тохиолдолд “СҮҮ” ХК-ийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох бичиг баримтыг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “СҮҮ” ХК /М.Мандхай/-д үүрэг болгосугай.

7. Энэ тогтоолын 2, 3-д заасан хувьцааг стратегийн болон олон нийтэд санал болгон худалдах чиглэлээр дээд зэргийн хүчин чармайлт гарган анхдагч зах зээлд арилжих үйл ажиллагааг зохион байгуулж, арилжигдаагүй үлдсэн үнэт цаасыг өөрийн хөрөнгөөр худалдан авахыг “Нэйшил сэкоритис УЦК” ХХК /Ц.Наран-Учрал/-д үүрэг болгосугай.

8. Энэ тогтоолын 7-д заасан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох хүртэлх арга хэмжээ авахыг “Нэйшил сэкоритис УЦК” ХХК /Ц.Наран-Учрал/-д анхааруулсугай.

9. Энэ тогтоолын 2-т заасан хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд буй хувьцааг 6 сарын хугацаанд тусгаарлахыг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ж.Байгалмаа/-д үүрэг болгосугай.

10. Хороо анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцох хүртэлх хугацаанд үнэт цаасны арилжаанаас татан төвлөрүүлэх хөрөнгийг тусгаарлахыг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ж.Байгалмаа/-д үүрэг болгосугай.

11. Үнэт цаасны танилцуулга, холбогдох бичиг баримтыг бэлтгэхэд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, зөрүүтэй, алдаатай мэдээлэл тусгасны улмаас хөрөнгө оруулагчид хохирол учруулсан тохиолдолд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9.14-т заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Нэйшил сэкоритис УЦК” ХХК /Ц.Наран-Учрал/, “Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН /Ж.Майзориг/, “Файн эстимэйт” ХХК /Ч.Отгончимэг/, “Дөлгөөнхайрхан уул аудит” ХХК /Б.Пүрэвдүлам/-д тус тус анхааруулсугай.

12. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-д үүрэг болгосугай.

